



VII-IX/2021


Тархаасан: 2021 оны 11 дүгээр сарын 16



Нэг ажиллагчид ногдох ДНБ, 2021 оны 3 дугаар улиралд 2.3 хувиар өслөө

Нэг ажиллагчид ногдох ДНБ (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 2021 оны 3 дугаар улиралд 5.8 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 127.6 (2.3%) мянган төгрөгөөр өссөн байна.

ЗУРАГ 1. НЭГ АЖИЛЛАГЧИД НОГДОХ ДНБ, улирлаар, сая төгрөгөөр



Ерөнхий 4 салбараар авч үзвэл, нэг ажиллагчид ногдох ДНБ буюу хөдөлмөрийн бүтээмж 2021 оны 3-р улиралд өмнөх оны мөн үеэс үйлчилгээний салбарт өсөж, хөдөө аж ахуй, уул уурхай олборлолт, аж үйлдвэр, барилгын салбарт буурсан байна.

ЗУРАГ 2. НЭГ АЖИЛЛАГЧИД НОГДОХ ДНБ, салбараар, жил бүрийн 3 дугаар улиралд, сая төгрөгөөр



Үйлчилгээний салбарын нэг ажиллагчид ногдох нэмэгдэл өртөг 4.8 сая төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 414.3 (9.5%) мянган төгрөгөөр нэмэгдсэн бол хөдөө аж ахуйн салбарынх 3.9 сая төгрөг болж, 105.4 (2.6%) мянган төгрөгөөр, уул уурхай, олборлолтын салбарынх 16.8 сая төгрөг болж, 2.1 (11.3%) сая төгрөгөөр, аж үйлдвэр, барилгын салбарынх 3.8 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 380.1 (9.1%) мянган төгрөгөөр тус тус буурчээ.

Ойлголт, тодорхойлолт

Бүтээмж нь улс оронд бий болсон үйлдвэрлэл, үйлчилгээний үр ашгийн үзүүлэлт бөгөөд үйлдвэрлэл (гарц), орцын харьцаагаар тодорхойлно.

Хөдөлмөрийн бүтээмж нь нэг ажиллагчид ногдох бодит ДНБ-ээр хэмжигдэнэ. Хөдөлмөрийн бүтээмжийн тооцоонд ашиглаж буй ДНБ-д өөрийн эзэмшлийн орон сууцны хийсвэр түрээсийг тусгаагүй болно.

Тооцох аргачлал:

Хөдөлмөрийн бүтээмжийг ДНБ (нэмэгдэл өртөг)-ий хэмжээг ажиллагчдын тоонд хувааж тооцно.

$$P = \frac{Q}{L}$$

P – хөдөлмөрийн бүтээмж

Q – дотоодын нийт бүтээгдэхүүн (нэмэгдэл өртөг)

L – ажиллагчдын тоо



Эх үүсвэр:

Үндэсний Статистикийн Хорооны албан ёсны статистикийн мэдээлэл

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 2 дугаар сарын 17

Бодлого, хамтын ажиллагааны
газрын дарга Б.Саранчимэг
Утас : (976-11)-323152

Бодлого, хамтын ажиллагааны газрын
Үндэсний тооцооны хэлтэс
Утас : (976-51)-262767



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212